



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/32

Алтрага

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Засаг даргын Тамгын газрын түлш халаалт" 22,000,000 (хорин хоёр сая) төгрөгийн өртөгтэй ажлыг нийлүүлэх аж ахуйн нэгж сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Баярхүү  
(Засаг даргын Тамгын газрын нярав)  
Гишүүд: Т.Батбямба  
(Байгаль хамгаалагч)  
З.Наранцэцэг  
(Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)  
Б.Мөнхбат  
(Бэлтэс 5 дугаар багийн Засаг дарга)  
Нарийн бичгийн дарга: Л.Чимэдцэрэн  
(Засаг даргын орлогч)

2.2024 оны Орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Засаг даргын Тамгын газрын түлш халаалт"-ын ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Баярхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОДСЭР

Document-Zahiramg

**6729010074**